



**БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ**

**НИЙГМИЙН ЗАЙЛШГҮЙ ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАН ГАЗАР ЧӨЛӨӨЛӨХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2021 он

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл /цаашид "хуулийн төсөл" гэх/-д шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж, түүний үр нөлөөг тооцож, хуулийн төслийг боловсронгуй болгоход энэхүү үнэлгээний ажлын зорилго нь оршино.

Энэхүү үнэлгээг Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулагдсан байна.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталдсан "Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал"-д /цаашид "Аргачлал" гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах; хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа

2.1.Хуулийн төлийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

"Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох, хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц байна уу гэдгийг тогтоох зорилгоор сонгосон болно.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хувьд уг хууль нь процессын хууль тул уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэх, хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтооход туршилтын ажиллагааг явуулах шаардлагагүй, цаг хугацааны боломж хомс байсан тул сонгож аваагүй болно. Практикт газар өмчлөгч, газрын эрх бүхий этгээдийн газрыг нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор буцаан авах тухай хуулийн зохицуулалт тодорхойгүй, иргэдэд ойлгомжгүй, тухайн үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаарх зохицуулалт тусгагдаагүй зэрэг нь газар чөлөөлөх үйл ажиллагаанд хүндрэлтэй байна.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын эрх, үүрэг, тэдгээрийн ашиг сонирхол хөндөгдөж байгаа эсэхийг тодруулах зорилгоор сонгож авсан.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлт нь хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг. Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах, тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалт нь холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийсэн.

“Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь нэмэлт зардал үүсэхгүй гэж үзсэн бөгөөд зардлын тооцооны тайланд дэлгэрэнгүй тусгасан болно.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэ хэсэгт хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно.

Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй зүйл заалтын үр нөлөөг судална.

3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийсэн.

Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төслийн зорилго нь төрөөс нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар өмчлөгч, газрын эрх бүхий этгээдтэй харилцан тохиролцож газрыг бүгдийг буюу зарим хэсгийг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах, хэрэв тохиролцоонд хүрээгүй бол газрыг чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэ зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Тухайлбал:

- Газар өмчлөгч, газрын эрх бүхий этгээдийн газрыг харилцан зөвшилцөж, нөхөн олговортойгоор, гэрээ хийх замаар чөлөөлөх;
 - Тохиролцож чадаагүй бол газар чөлөөлөх шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх
- Хуулийн төслөөс дээрх зорилтуудтай холбогдсон зүйл заалтыг сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ийн үр нөлөөг нь тооцно. Үүнд:

№	Зорилгод хүрэх байдал /дагалдах зорилтууд/	Сонгосон зүйл заалт
1	Газар өмчлөгч, газрын эрх бүхий этгээдийн газрыг харилцан зөвшилцөж, нөхөн олговортойгоор, гэрээ хийх замаар чөлөөлөх;	Хуулийн төслийн 8, 12-14 дугаар зүйл
2	Тохиролцож чадаагүй бол газар чөлөөлөх шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх	Хуулийн төслийн 27, 28 дугаар зүйл

3.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно.

3.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэж байгаа эсэхийг шалгав.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Сонгосон зүйл заалт
12.5.Нөхөх олговрын үнэлгээг газар чөлөөлөлтөд өртөгчтэй зөвшилцөнө.	Хуулийн төслийн 12.5.
14.2.Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасныг баримтлан газар чөлөөлөлтөд өртөгч нарт сонсох ажиллагаа аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага явуулна.	Хуулийн төслийн 14.2.

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 8, 12-14, 27, 28 дугаар зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь тооцно	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд

			заасан асуулгаар хуулийн төслийг шалгах
3	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн 12.5., 14.2.	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх асуудлын хүрээнд, холбогдох байгууллагуудаас бичгээр санал авах, холбогдох мэргэжилтэнтэй фокус ярилцлага хийх
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь тооцно	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах
5	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно	Зардлын тооцоо хийх

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ:

4.2. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газрын эрх бүхий этгээдтэй харилцан зөвшилцөж газрыг нөхөх олговортойгоор авах замаар газар чөлөөлөх зорилтын хүрээнд хуулийн төслийн 14 дүгээр зүйлд дүн шинжилгээ хийсэн байдал.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэх үүднээс хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Газар чөлөөлөлтөд өртөгч мэдэгдлийг хүлээн авч, газар чөлөөлөх асуудлаар хэлэлцээ хийх бөгөөд хэлэлцээ хийхдээ газар, үл хөдлөх хөрөнгийг эзэмшиж байгаа нотлох баримтыг авчирна.”, 14.5-д “Хэлэлцээр амжилттай болж аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн байгууллага, газар чөлөөлөлтөд өртөгч тохиролцоонд хүрсэн бол талууд газар чөлөөлөх гэрээ байгуулна.” гэж заасан нь харилцан ашигтай байх, газар чөлөөлөх үйл ажиллагааг зөвшилцөлийн дагуу ил тод зохион байгуулах зорилтыг хангаж байна.

Газар чөлөөлөх нөлөөлөлд өртөгчид нөхөх олговор тооцох, түүнийг олгох зорилтын хүрээнд хуулийн төслийн 12 дугаар зүйлд дүн шинжилгээ хийсэн байдал.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэх үүднээс хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нөхөн олговрын үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан зарчим, арга, аргачлалын дагуу тогтооно.”, 12.2-т “Нөхөн олговрын үнэлгээг хийх зарчим, аргачлал, арга нь бүх нөхөн олговрын үнэлгээнд ижил, нээлттэй, ил тод байна.” гэж заасан нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх үйл ажиллагааны үндсэн зарчим, зорилгыг бүрэн хангаж байна.

4.2. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан “Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага”,

30 дугаар зүйлд заасан “Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага хангасан эсэх” мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримтлан, хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд хуулийн төсөл нь нийтлэг байдлаараа хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Хуулийн төслийн зүйл заалтууд нь бүхэлдээ Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байна
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн Харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх	Шинэ хуулийн төсөл учир одоо мөрдөгдөж буй нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг тусгасан бөгөөд нийгмийн харилцааны зохицуулалтад шинэлэг өөрчлөлт орохоор байна
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх	Хуулийн хүрээнд нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгаагүй болно
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах, энэ тохиолдолд ишлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Бусад хуулийн заалт, ишлэлийг заасан байна.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин	Шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулсан байна

төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт	
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх	Бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон дагалдах хуулийн төсөл байхгүй
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгах	Хуулийн зорилтод иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгасан байна
Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй

4.3.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн 6 дугаар зүйлд шинжилгээ хийсэн байдал

Хуулийн төсөлд газрыг чөлөөлөхдөө холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр, зөвхөн 19 төрлийн зориулалтаар чөлөөлөх бөгөөд холбогдох зураг төсөл, газар чөлөөлөх зардлыг тодорхой болгосоны дараа газар чөлөөлөлтөд өртөгч нартай харилцан хэлэлцээр хийх замаар энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Газрыг чөлөөлөхдөө судалгаа хийх бөгөөд сонсох ажиллагаа явуулах, нөхөх олговрын үнэлгээ хийх, зөвшилцөх, гэрээ байгуулах, баримтжуулах зэрэг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан байна.

Энэ нь хүний эрхийг хангах, хамгаалах, харилцан ойлголцох байдлаар хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн гэж үзэж байна.

4.4.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалснаар хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах зорилготой.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараахь асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн зохицуулалт нь тодорхой зорилтуудыг дэвшүүлэн тэдгээр зорилтуудад хүрэх шууд утга бүхий заалтуудыг оруулсан тул зорилтдоо хүрсэн гэж үзлээ
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	“нийгмийн зайлшгүй хэрэгцээ” гэж нийтэд зайлшгүй шаардлагатай нийгмийн болон инженерийн дэд бүтцийн барилга байгууламжийг барих, өргөтгөх зорилгоор улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг; “газар чөлөөлөх” гэж энэ хуульд заасан журмын дагуу нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газрын эрх бүхий этгээд болон бусад этгээдтэй харилцан тохиролцож, зөвшилцөх замаар газрыг төрийн өмчлөлд буцаан авахыг; “газар чөлөөлөлтөд өртөгч” гэж энэ хуулийн дагуу газрыг чөлөөлөхөд хүрсэн, үүний улмаас газрын эрхээр олгогдсон болон гэрээгээр ашиглаж буй газар, үл хөдлөх эд хөрөнгө, амьдрах нөхцөл, ажлын байр, бизнесийн үйл ажиллагаа явуулах боломжоо алдаж байгаа нь нотлогдсон иргэн, хуулийн этгээдийг; “газрыг чөлөөлөх шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх” гэж газар чөлөөлөлтөд өртөгч ба газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах, нөхөх олговор олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэгч төрийн байгууллага харилцан тохиролцож гэрээ байгуулж чадаагүй тохиолдолд шүүхийн шийдвэрийг үндэслэн газар чөлөөлөхийг;
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байна.
Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан зүйл тогтоогдоогүй.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.
Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан зүйл тогтоогдоогүй.

Хуулийн төсөлд Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төсөлд Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зүйл тогтоогдоогүй.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон тухай ямар нэгэн зүйл заалт тусгаагүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтын талаар тусгагдаагүй байна. Харин хуулийн төслийн 13.2-т “Газар, үл хөдлөх хөрөнгийн нөхөх олговрын үнэлгээг хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий үнэлгээчин хийнэ.” гэж заасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг өөр хуулиар зохицуулахаар тусгасан байна.
Хуулийн төслийн зүйл, заалт нь жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөлд жендерийн эрх тэгш байдал хөндөгдөөгүй.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгах шаардлагатай.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1. Дүгнэлт, зөвлөмж

Хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэх ажиллагааг гүйцэтгэлээ.

Хуулийн төслийн үнэлгээг хийхдээ дээрх аргачлалыг чанд баримтлан, аргачлалд заасан дараахь шалгуур үзүүлэлтийг сонгон авч, уг шалгуур үзүүлэлтийг илтгэх зүйл, хэсэг, заалт бүрийг үнэлэв. Үүнд:

- Зорилгод хүрэх байдал
- Хүлээн зөвшөөрөгдөх байдал
- Ойлгомжтой байдал
- Харилцан уялдаа
- Зардал

Хуулийн төслийн үр нөлөөг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай

хуулийн төсөл нь тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад үндсэндээ нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлалаас зорилгыг тодорхойлж, эдгээр зорилгод хуулийн төслийн зүйл заалт хэрхэн нийцэж байгаад үнэлгээ хийсэн. Үнэлгээний дагуу хуулийн төслийн зорилго нь төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан гэж үзэж байна.

Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх үйл ажиллагааг хуульд заасан үндэслэлээр, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурлан, харилцан зөвшилцөх замаар нөхөн олговортойгоор газрыг чөлөөлөх харилцааг зохицуулахыг зорьсон бөгөөд хуулийн төслийн зорилгод нийцсэн, зорилгодоо хүрэх байдал нь эерэг байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага хангаж, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу хийгдсэн байна.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 17 дугаар зүйлд “Хэний ч өмч хөрөнгийг дураар хураан авч болохгүй” гэж заасан.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2. Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасныг баримтлан газар чөлөөлөлтөд өртөгч нарт сонсох ажиллагаа явуулах бөгөөд зарыг албан хэрэгцээний цахим хуудсанд ажлын 10 өдрийн турш байршуулахаас гадна үндэсний хэмжээний өдөр тутмын 2-оос доошгүй сонинд, 2 өдрийн турш нийтлүүлж нийтэд мэдээлнэ. 14.4. Газар чөлөөлөлтөд өртөгч мэдэгдлийг хүлээн авч, газар чөлөөлөх асуудлаар хэлэлцээ хийх бөгөөд хэлэлцээ хийхдээ газар, үл хөдлөх хөрөнгийг эзэмшиж байгаа нотлох баримтыг авчирна. 14.5. Хэлэлцээр амжилттай болж аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн байгууллага, газар чөлөөлөлтөд өртөгч тохиролцоонд хүрсэн бол талууд газар чөлөөлөх гэрээ байгуулна. 14.6. Нөхөн олговрын 60 хувийг газар чөлөөлөлтөд өртөгчтэй газар чөлөөлөх гэрээ байгуулснаар, үлдэгдэл 40 хувийг газар чөлөөлсний дараа болон гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараа олгоно, гэж заасантай нийцэж байгаа нь эерэг байна.

Өөрөөр хэлбэл нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөхдөө газар чөлөөлөлтөд өртөгч нартай зөвшилцөж, газар, үл хөдлөх эд хөрөнгийн нөхөн олговрын үнэлгээг бүрэн хийж, холбогдох гэрээг байгуулж, нөхөн олговрыг бүрэн олгосны дараа газрыг чөлөөлөхөөр тусгасан нь хүний эрхийг хангах үндсэн нөхцлийг бүрдүүлжээ.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэлэхэд эерэг байна.

Зардал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Зардлын тооцоог тусдаа тайлангаар хавсаргав.